



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/647

Булган сум

Газар эзэмших эрхийг дуусгавар болгож,
газар ашиглуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 44 дүгээр зүйлийн 44.5, 44.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хаан банк” ХК (РД:2693321) нь гадаадын хөрөнгө оруулалттай компани тул Булган сумын 6 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 1 дүгээр гудамж 108 тоотод байршилтай 6308007754 нэгж талбар бүхий банк, санхүүгийн байгууллага зориулалтаар эзэмшиж буй 1299 м² газрын газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2.“Хаан банк” ХК (РД:2693321)-д Булган сум 6 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 1 дүгээр гудамж 108 тоот байршилтай 1299 м² газрыг банк, санхүүгийн байгууллага зориулалтаар 5 жилийн хугацаатай ашиглуулсугай.

3.“Хаан банк” ХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй газар ашиглуулах гэрээ байгуулж, гэрчилгээжүүлэн газар ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2011 оны Б/229 дүгээр захирамжийн “Хаан банк” ХК-тай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

6334010893